

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоодхяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГААЛЬ, ТАТВАР, САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ Т.БАТБИЛЭГ
ТАНАА

2020.02.27 № 06/623
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Т.Батбилэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн зардлын дансны нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 02-ноос 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал Ж.Цэцэгмаа, ахлах аудитор С.Дашдондог, аудиторын туслах Э.Болд, Г.Ундармаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдөр 01/55 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн болно.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АОУС, АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Гааль татвар санхүүгийн салбарт мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, цахим засаглалыг бэхжүүлэхэд чиглэгдэнэ" гэж тодорхойлжээ.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагааны чиглэл нь Монгол Улсын гааль, татварын бүртгэл, мэдээллийн "нэгдсэн систем"-ийг нэвтрүүлэх, техник технологийн хэвийн үйл ажиллагааг хариуцан ажиллах, мөн мэдээллийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган ажиллахаар тодорхойлогджээ.

2019 онд УИХ-ын чуулганы хуралдаанаар батлагдсан Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан дараах системүүд дээр хөгжүүлэлт хийн ажиллаж байна. Үүнд:

- Цахим төлбөрийн баримтын систем
- Цахим тайлангийн систем
- Татвар төлөгчийн бүртгэлийн систем
- Татварын удирдлагын нэгдсэн систем
- Бараа бүртгэлийн нэгдсэн систем
- Ухаалаг тайлангийн систем
- Төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн систем
- Хөрөнгө оруулагчдын цахим бүртгэлийн систем
- Онцгой албан татварын тэмдгийн хяналтын систем

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь үйл ажиллагаандаа дараах хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Засгийн газрын 2016 оны 177 тоот тогтоолоор батлагдсан "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-ын дүрэм
- Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 тоот "Журам батлах тухай" тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 тоот "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тогтоол.
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 тоот "Төрийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол
- Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 тоот "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам" тушаал

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоодхяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн одоогийн мөрдөж байгаа Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 253 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого"-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба байгууллагынхаа онцлогт тохируулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөх шаардлагатай байна.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Имиралд" программ хангамж ашигладаг байна.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд 5 горим, сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АОУС 320, АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт нийт зардлын дүн 1,179,707.6 мянган төгрөгөөс 2.0 хувиар бодож 23,594.2 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,957,635.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар тооцон 59,152.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг шинэчлэн тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,730.3 мянган төгрөгөөр буюу 16.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	37.0	11.2	(25.8)
Бараа материал	3,253.6	6,224.5	2,970.9
Үндсэн хөрөнгө	346,193.6	292,518.2	(53,675.4)
Нийт хөрөнгө	349,484.2	298,753.9	(50,730.3)
Өр төлбөр	215.0	0.0	(215.0)
Засгийн газрын хувь оролцоо	349,269.1	298,753.8	(50,515.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	349,484.1	298,753.8	(50,730.3)

Бараа материалын дансны үлдэгдэл 2,970.9 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалт нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант онд нийт 3,324.7 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын худалдан авалт хийж нөөц үүсгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 53,675.4 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А-1/4434 тоот албан бичгийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23,977.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актласан, тайлант онд 171,353.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас тус тус шалтгаалсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны НДШ-ийн өглөг 214.9 мянган төгрөгийг төлж барагдуулсантай холбоотой ба бэлтгэн нийлүүлэгч худалдан авагч байгууллагад өр төлбөрийн тооцоо үүсгээгүй байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 2,883,412.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл нь 2,652,346.3 мянган төгрөгийг зарцуулж төсвийн гүйцэтгэл 92.0 хувь байна.

Өөрийн үйл ажиллагаанаас Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газарт программ хөгжүүлэх үйлчилгээ үзүүлснээс 23,707.3 мянган төгрөгийн орлого олсон байна.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 104,921.3 мянган төгрөг, бусад зардал 2,411.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж, тэтгэмж, урамшууллын 100,000.0 мянган төгрөг зарцуулаагүй ба нийт зардлыг 207,333.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл нийт 7 эрсдэлийг тодорхойлж 7 горим, сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,380.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 180.0 мянган төгрөгийн 1 зөрчилд акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3 зөрчлийг залруулж, 9,200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Бичиг хэргийн зүйлс хувь хүнээс худалдан авсан 1,800.0 мянган төгрөгөөс Хувь хүний орлогын албан татвар болох 180.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д "үйл ажиллагааны орлого" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь тайлант онд Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ" гэсэн заалтыг зөрчиж 168 мэдээллийг байршуулахаас 29 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар гадаад төлбөр тооцоог хувь хүний олон улсын гүйлгээний эрхтэй дансаар дамжуулан хийдгийг анхаарч үзэх.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 29 мэдээллийг хугацаанаас нь хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,616.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНБОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр
зөвлөмжийг та бидний хамт янажиллагааны байрсууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Зардлын данстай холбоотой асуудал

1.1 **Илрүүлэлт:**

Гадаад болон дотоод томилолтын зардлаас анхан шатны баримтын бүрдэл дутуу 7200,0 мянган төгрөг байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.7-д заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2 **Эрсдэл:**

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгагдсан.

1.3 **Өгсөн зөвлөмж:**

Албан томилолтын зарцуулалтын тайланг хугацаанд нь гаргуулж, зохих хууль журмын дагуу тооцоог нь бодож хэвших

1.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

2019 оны бүх томилолтын тайланг дахин нягтлан шалгаж баримтжуулан архивлана.

2.1 **Илрүүлэлт:**

Зардлын баримтад Е-баримтаар баталгаажуулахгүй 2,000.0 мянган төгрөгийн баримт байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 **Эрсдэл:**

Төсвийг хэтрүүлэн зарцуулж, үр ашиггүй зардал гаргах.

2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид бараа материалыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авахдаа е-баримт олгодог, баталгаатай газрыг сонгох

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Худалдан авалт бүрээ И-баримтаар баталгаажуулж, тайланд тусгана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,290,533.00	6,235,653.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	36,950.00	11,175.89
31211	Төрийн сангийн харилцах	36,950.00	11,175.89
35	БАРАА МАТЕРИАЛ	3,253,583.00	6,224,478.00
354	Хангамжийн материал	3,253,583.00	6,224,478.00
35410	Бичиг хэргийн материал	298,000.00	2,337,780.00
35420	Аж ахуйн материал	167,598.00	97,698.00
35470	Бусад хангамжийн материал	2,787,985.00	3,789,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	346,193,575.92	292,518,192.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	346,193,575.92	292,518,192.40
392	Биет хөрөнгө	342,239,891.78	282,917,556.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	568,012,792.60	636,408,514.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-293,059,143.86	-431,725,905.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	78,197,348.56	99,261,448.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,870,100.93	-26,080,622.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,466,064.50	13,728,994.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,507,069.09	-8,674,874.06
393	Биет бус хөрөнгө	3,953,684.14	9,600,636.28
39301	Програм хангамж	11,425,413.00	7,425,413.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,903,278.86	-6,499,006.41
39303	Бусад биет бус хөрөнгө	1,233,000.00	11,211,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-801,450.00	-2,536,770.31
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	349,484,108.92	298,753,846.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	214,984.29	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	214,984.29	0.00
413	Өглөг	214,984.29	0.00
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	214,984.29	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	349,269,124.63	298,753,846.29
51	Засгийн газрын хувь оролцоо	349,269,124.63	298,753,846.29
512	Хуримтлагдсан үр дүн	349,269,124.63	298,753,846.29
51210	Өмнөх үеийн үр дүн	387,103,720.94	349,269,124.63
51220	Тайлант үеийн үр дүн	-37,834,596.31	-50,515,278.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	349,484,108.92	298,753,846.29

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,272,550,500.00	2,907,119,724.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	23,707,324.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	23,707,324.00
120009	Бусад орлого	0.00	23,707,324.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,272,550,500.00	2,883,412,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,272,550,500.00	2,883,412,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,272,550,500.00	2,883,412,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,310,385,096.31	2,957,635,002.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,310,385,096.31	2,957,635,002.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,310,385,096.31	2,726,568,865.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,328,077,031.70	879,350,100.00
210101	Үндсэн цалин	1,214,392,715.38	879,350,100.00
210102	Нэмэгдэл цалин	84,763,216.32	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,921,100.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,285,430.92	109,918,800.00
210201	Тэтгэврийн даатгал	126,285,430.92	109,918,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,264,279.47	286,514,070.67
210301	Гэрэл цахилгаан	13,970,912.01	5,313,424.00
210302	Түлш, халаалт	1,217,851.17	0.00
210303	Цэвэр, бохир ус	682,872.02	0.00
210304	Байрны түрээс	71,453,118.27	109,847,509.15
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	149,939,526.00	171,353,137.52
2104	Хангамж, бараа материалын зардал	10,930,400.01	16,798,903.20
210401	Бичиг хэрэг	3,137,570.00	3,955,310.00
210402	Тээвэр шатахуун	2,903,000.00	2,560,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	119,465.01	352,980.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,770,365.00	9,930,613.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,556,002.00	17,060,076.00
210601	Багаж, техник хэрэгсэл	1,556,002.00	16,897,956.00
210604	Урсгал засвар	0.00	162,120.00
2107	Томилолт, зочны зардал	18,335,600.00	19,001,070.00
210701	Гадаад албан томилолт	0.00	4,375,020.00
210702	Дотоод албан томилолт	16,310,000.00	13,622,950.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,025,600.00	1,003,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	543,707,618.21	1,304,944,925.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	533,711,118.21	1,291,279,149.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,496,500.00	13,575,775.68
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,	0.00	90,000.00

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,228,734.00	92,980,920.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,228,734.00	39,348,509.57
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	0.00	53,632,411.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	231,066,136.49
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	231,066,136.49
261090	УТБ-н татан төвлөрүүлэлт	0.00	231,066,136.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-37,834,596.31	-50,515,278.34
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-37,834,596.31	-50,515,278.34

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,272,550,500.00	2,907,119,724.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	23,707,324.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	23,707,324.00
120009	Бусад орлого	0.00	23,707,324.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,272,550,500.00	2,883,412,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,272,550,500.00	2,883,412,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,272,550,500.00	2,883,412,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,272,527,182.00	2,907,145,498.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,272,527,182.00	2,907,145,498.11
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,272,402,111.91	2,676,079,361.62
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	887,648,417.64	879,350,100.00
210101	Үндсэн цалин	671,453,006.01	706,965,614.50
210102	Нэмэгдэл	154,058,458.60	135,410,635.50
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	28,968,131.23	22,731,850.00
210104	Урамшуулал	33,168,821.80	14,242,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,519,900.00	109,918,800.00
210201	Тэтгэврийн даатгал	68,054,200.00	100,758,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,916,700.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,169,300.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	147,900.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,231,800.00	9,160,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,736,800.00	75,736,800.00
210301	Гэрэл, цахилгаан	5,949,254.16	2,631,859.71
210302	Түлш, халаалт	1,549,124.55	0.00
210303	Цэвэр, бохир ус	858,303.02	0.00
210304	Байрны түрээс	67,380,118.27	73,104,940.29
2104	Хангамж, бараа материалын зардал	11,335,564.41	11,341,200.00
210401	Бичиг хэрэг	3,426,570.00	2,443,090.00
210402	Тээвэр, шатахуун	2,903,000.00	2,810,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,220.41	51,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,948,774.00	6,036,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,650,000.00	79,701,626.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,650,000.00	79,701,626.00
2107	Томилолт, зочны зардал	17,810,000.00	17,726,300.00
210702	Дотоод албан томилолт	16,310,000.00	16,226,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,070,701,429.86	1,323,825,522.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,048,201,429.86	1,301,499,848.71

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,499,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,000,000.00	19,825,774.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000,000.00	178,479,012.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000,000.00	99,999,431.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	78,479,581.00
212	ТАТААС	125,070.09	231,066,136.49
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	125,070.09	231,066,136.49
260301	Татаас шилжүүлэг	125,070.09	231,066,136.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,318.00	-25,774.11
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,318.00	-25,774.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,632.00	36,950.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,950.00	11,175.89

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	387,103,720.94	387,103,720.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	387,103,720.94	387,103,720.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-37,834,596.31	-37,834,596.31
C08	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	349,269,124.63	349,269,124.63
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	349,269,124.63	349,269,124.63
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-50,515,278.34	-50,515,278.34
D08	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0.00	0.00	298,753,846.29	298,753,846.29

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	36,950.00		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,883,412,400.00	2,676,079,361.62	207,333,038.38	92.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,883,412,400.00	2,676,079,361.62	207,333,038.38	92.8
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,783,412,400.00	2,676,079,361.62	107,333,038.38	96.1
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	879,350,100.00	879,350,100.00	-	100.0
210101	Үндсэн цалин	677,896,600.00	706,965,614.50	(29,069,014.50)	104.3
210102	Нэмэгдэл цалин	150,464,800.00	135,410,635.50	15,054,164.50	90.0
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	33,264,000.00	22,731,850.00	10,532,150.00	68.3
210104	Урамшуулал	17,724,700.00	14,242,000.00	3,482,700.00	80.4
210105	Гэрээт ажлын цалин	-	-	-	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,918,800.00	109,918,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	100,758,800.00	100,758,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	-	-	-	
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	-	-	
210204	Ажилгүйдлийн даатгал	-	-	-	
210205	Эрүүл мэндийн даатгал	9,160,000.00	9,160,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,736,800.00	75,736,800.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,738,800.00	2,631,859.71	2,106,940.29	55.5
210302	Түлш, халаалт	2,079,000.00	-	2,079,000.00	-
210303	Цэвэр, бохир ус	1,287,000.00	-	1,287,000.00	-
210304	Байрны түрээс	67,632,000.00	73,104,940.29	(5,472,940.29)	108.1
2104	Хангамж, бараа материалын зардал	11,341,200.00	11,341,200.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	6,058,800.00	2,443,090.00	3,615,710.00	40.3
210402	Тээвэр, шатахуун	3,534,300.00	2,810,000.00	724,300.00	79.5
210403	Шуудан, холбоо,				

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	интернэтийн төлбөр	545,300.00	51,350.00	493,950.00	9.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,202,800.00	6,036,760.00	(4,833,960.00)	501.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,702,000.00	79,701,626.00	374.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	79,702,000.00	79,701,626.00	374.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	17,810,000.00	17,726,300.00	83,700.00	99.5
210702	Дотоод албан томилолт	16,310,000.00	16,226,300.00	83,700.00	99.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,428,746,800.00	1,323,825,522.82	104,921,277.18	92.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,406,246,800.00	1,301,499,848.71	104,746,951.29	92.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,499,900.00	100.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,000,000.00	19,825,774.11	174,225.89	99.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	180,806,700.00	178,479,012.80	2,327,687.20	98.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000,000.00	99,999,431.80	568.20	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	80,806,700.00	78,479,581.00	2,327,119.00	97.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,000,000.00	-	100,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000,000.00	-	100,000,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	100,000,000.00	-	100,000,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,883,412,400.00	2,676,053,587.51	207,358,812.49	92.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,883,412,400.00	2,652,346,263.51	231,066,136.49	92.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,883,412,400.00	2,652,346,263.51	231,066,136.49	92.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	23,707,324.00	(23,707,324.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	23,707,324.00	(23,707,324.00)	
4	Төсвийн гүйцэтгэл тохируулах орлого, зардал	0.00	0.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	0.00	11,175.89	(11,175.89)	

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	эцсийн үлдэгдэл				
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	35	35	-	
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	
620004	Гэрээт ажилтан	18	18	-	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.17	Аудитын нэр: Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/90/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв	мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь гадаад болон дотоод томилолтын зарцуулалтын тайланг гаргуулаагүй.	7,200.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Загдсүрэн
2	Зардлын баримтууд Е-баримтаар баталгаажаагүй	2,000.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Г.Загдсүрэн
3	Шилэн дансны мэдээллийг тухай бүрд нь хугацаанд нь оруулаагүй.		Албан шаардлага өгөх	Захирал, Нягтлан бодогч	Т.Батбилэг Г.Загдсүрэн
4	Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь бичиг хэргийн зүйлс хувь хүнээс худалдан авсан 1,800.0 мянган төгрөгөөс ХХОАТ суутган тооцоогүй.	180.0	Акт тогтоох	Нягтлан бодогч	Г.Загдсүрэн
	Нийт дүн	9,380.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/123

Улаанбаатар хот

С.Ө.Н. 2020/30/СТЭ-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв нь тайлант онд шилэн дансанд 168 мэдээллийг байршуулахаас 29 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "дараах зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг тухай бүрд нь цаг хугацаанд нь оруулах.
2. Зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн захирал Т.Батбилэг, ерөнхий нягтлан бодогч Г.Загдсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР *Г.Мөнхчимэг* Г.МӨНХЧИМЭГ
РЕЛАЗНС СЕКЮРИТИЗ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.Цэцэгмаа Ж.ЦЭЦЭГМАА

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ

Т.Батбилэг Т.БАТБИЛЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

Г.Загдсүрэн Г.ЗАГДСҮРЭН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь залах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/57

Улаанбаатар хот

САГ-2020/190/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бичиг хэргийн зүйлс хувь хүнээс худалдан авсан 1,800.0 мянган төгрөгөөс Хувь хүний орлогын албан татвар болох 180.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй.

Энэ нь тухайн үед хүчин төгөлдөр байсан 2006 оны Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д "үйл ажиллагааны орлого" заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- 180.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх, төлбөрийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
- Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвийн захирал Т.Батбилэг, ерөнхий нягтлан бодогч Г.Загдсүрэн нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР *Ц.НАРАНЧИМЭГ*


АУДИТОР *Г.МӨНХЧИМЭГ*
"РЕЛЭЭНС СЕКЮРИТИЗ АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ж.ЦЭЦЭГМАА

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ *Т.БАТБИЛЭГ*

НЯГТЛАН БОДОГЧ *Г.ЗАГДСҮРЭН*



001090139

